21

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 15 өдөр Дугаар А/08 Шивээговь сум

Нийтийн их цэвэрлэгээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, 9.4.12, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын төвийн нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг 14 хоног тутмын Баасан гарагт суманд үйл ажиллагаа явуулж буй бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, бямба гарагт айл өрх, нийт иргэдийн дунд тогтмол зохион байгуулсугай.

2. ААНБ, иргэдийн нийтийн их цэвэрлэгээ хийх хуваарийг 1 дүгээр хавсралтаар, сумын эзэнжүүлсэн талбайн хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хуваарийн дагуу өөрийн байгууллагынхаа хуваарьт газруудад цэвэрлэгээ, усалгаа арчилгаа хийлгэх, багаж хэрэгслээр хангах, цэвэрлэгээний ажилд ажилтан, албан хаагчдаа бүрэн хамруулах, цэвэрлэгээг чанартай хийж гүйцэтгэн хогийн цэгт ачиж тээвэрлэн, төвлөрүүлэхийг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Сумын төвийн нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн нарт даалгасугай.

5. Хууль тогтоомжийг зөрчсөн албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд хариуцлага тооцож ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Цагдаагийн хэсэг, багийн Засаг дарга нарт, Захирамжийн хэрэгжилтэнд хяналт

42125 020

тавьж, үр дүнг тухай бүр танилцуулахыг Засаг даргын орлогч /Л.Бадамханд/-д тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/35 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2025 оны
...01...-р сарын ...15...-ны өдрийн
А/08 дугаар захирамжийн 1-р хавсралт

**Албан байгууллага, Аж ахуй нэгж, иргэдийн 2025 онд хийх нийтийн их цэвэрлэгээний хуваарь**

| Сар / өдөр | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | | | |
| 9 | | | | | | | | | | | | |
| 10 | | | | | | | | | | | | |
| 11 | | | | | | | | | | | | |
| 12 | | | | | | | | | | | | |
| 13 | | | | | | | | | | | | |
| 14 | | | | | | | | | | | | |
| 15 | | | | | | | | | | | | |
| 16 | | | | | | | | | | | | |
| 17 | | | | | | | | | | | | |
| 18 | | | | | | | | | | | | |
| 19 | | | | | | | | | | | | |
| 20 | | | | | | | | | | | | |
| 21 | | | | | | | | | | | | |
| 22 | | | | | | | | | | | | |
| 23 | | | | | | | | | | | | |
| 24 | | | | | | | | | | | | |
| 25 | | | | | | | | | | | | |
| 26 | | | | | | | | | | | | |
| 27 | | | | | | | | | | | | |
| 28 | | | | | | | | | | | | |
| 29 | | | | | | | | | | | | |
| 30 | | | | | | | | | | | | |
| 31 | | | | | | | | | | | | |

Иргэд

Албан байгууллага, Аж ахуй нэгж

Сумын Засаг даргын 2025 оны
01 -р сарын 15 -ны өдрийн
А/08 дугаар захирамжийн 2 -р хавсралт




ЦАГДААГИЙН ХЭСЭГ
ЦАГДААГИЙН ХЭСЭГ
3-Р СУРГУУЛЬ
НАРЛАГ СӨХ


ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ
ИЛЧЛЭГ ШИВЭЭ ОНӨААТҮГ